

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Автотээврийн хэрэгслийн албан журмын даатгалын тогтолцоог анх 1930 онд Замын хөдөлгөөний тухай хуулиар Их Британи улсад нэвтрүүлж эхэлсэн бөгөөд тухайн хуулиар тээврийн хэрэгсэл эзэмшигчид болон жолооч нар нь зам тээврийн хөдөлгөөнд оролцох үедээ гуравдагч этгээдэд учруулж болзошгүй гэм хор, амь насны эрсдэлээс хариуцлагаа даатгуулах ёстой байв. Улмаар Герман улс 1939 онд ижил төстэй хууль тогтоомж болох "Автомашин эзэмшигчдийн албан журмын даатгалыг хэрэгжүүлэх тухай хууль"-ийг баталсан.

Харин Монгол Улсад Жолоочийн даатгалын тухай хууль нь 2011 онд батлагдан 2012 оноос мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хуулийн дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг Монгол Улсад хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бий болсон.

Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагааг улс орон даяар хэрэгжүүлж, автотээврийн хэрэгслийн өмчлөгч, жолооч нарыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх ердийн даатгагч нар (15 компани) болон даатгалын мэргэжлийн оролцогчид болох даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулан уг даатгалд хамруулж байгаа бөгөөд Албан журмын даатгагчдын холбоо нь жолоочийн даатгалын сан (даатгагчдын төвлөрүүлэх хөрөнгө, автотээврийн хэрэгслийн албан татварын 10% /2020 оны Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2019 оны 11 сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсон/ болон үйл ажиллагааны орлогоос бүрдэх), шуурхай алба болон мэдээллийн нэгдсэн санг эрхлэн явуулж, мөн зам тээврийн ослын хохирогчид хуульд заасан нөхцөл, тохиолдол бүрдэхэд жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгож, хохирогчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллаж байна.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь ердийн даатгалын зах зээл дэх (2023 оны эцсийн байдлаар) нийт даатгалын хураамжийн 12.1 хувь, нөхөн төлбөрийн 30.0 хувь, байгуулсан даатгалын гэрээний 52.6 хувийг эзэлдэг бөгөөд нийт байгуулагдсан гэрээний 49.6 хувь нь даатгалын төлөөлөгчдөөр дамжин улс орон даяар борлуулагддаг. Тус даатгал нь тээврийн хэрэгслийн, сайн дурын жолоочийн хариуцлагын даатгал, аяллын даатгал гэх мэт бусад төрлийн арилжааны даатгалуудтай хохирол, нөхөн төлбөр, харилцагчийн судалгаа, даатгалын залилангийн судалгаа гэх мэт дата мэдээллийн хувьд нягт холбогддог, олон улсын ердийн даатгалын зах зээлийн хураамж бүрдүүлэлтэд томоохон байр суурь эзэлдэг.

Даатгалын хураамжийн хэмжээг даатгалын хяналт, зохицуулалтын байгууллагын оролцоотойгоор тогтоодгоос гадна даатгалтай холбогдох маргаан шийдвэрлэлт, даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь нарийвчилсан зохицуулалт шаарддаг онцлог бүхий арилжааны даатгалын салшгүй нэг хэсэг юм. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хэрэгжиж эхэлснээс хойших 10 гаруй жилийн хугацаанд даатгагч, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгч компаниудад зөвхөн тус даатгалаар мэргэшин ажиллаж буй хэдэн зуун мэргэжилтэн, боловсон хүчин буй болж, салбар төлөөлөгчдийн газар

байгуулан, техник программ хангамжийг мөн тус даатгалын чиглэлээр хөгжүүлж ирсэн билээ.

Үүнээс үзэхэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь даатгалын салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлдэг даатгалын бүтээгдэхүүн болон хөгжиж, зам тээврийн ослоос үүссэн санхүүгийн хохирлыг нөхөн төлж, иргэд, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах хэрэгсэл болсон байна.

Санхүүгийн зохицуулах хороонд даатгалын асуудлаар ирүүлж байгаа өргөдлийн дунджаар 26.4 хувь (2016 онд 43.9%, 2017 онд 30.5%, 2018 онд 16.3%, 2019 онд 23.0%, 2020 онд 25.0%, 2021 онд 11.4%, 2022 онд 11.5%, 2023 онд 37.5% хувийг тус тус эзэлсэн) нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбогддог. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбоотой гомдлуудыг авч үзэхэд даатгагч нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан, даатгалын хохирлын үнэлгээ байх ёстой хэмжээнээс бага тогтоогдсон, шуурхай албаны үйл ажиллагаа, даатгалын үнэлгээний зөрүү, хураамж болон АЖДХ-ны үйл ажиллагаатай холбоотой гомдлууд дийлэнх хувийг эзэлж байна.

Энэ нь хуулийг боловсронгуй болгох, гадаад улс орнуудын албан журмын даатгалыг судалж, холбогдох сайн туршлагыг хэвшүүлэх, мөн хуулийн хамрах хүрээ, зохицуулалтуудыг боловсронгуй болгох, албан журмын даатгалын үйл ажиллагаанд техник технологи ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг зайлшгүй шаардлагууд үүсэж байгааг илтгэж байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 8 бүлэг, 26 зүйлтэй бөгөөд даатгалын үйлчилгээг сайжруулах, практикт тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэх замаар хохирогчийн эрхийг хамгаалахад чиглэсэн дараах өөрчлөлтүүдийг оруулж байна.

Зөвхөн зам тээврийн хөдөлгөөний улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөр олгох бүхий зохицуулалт, зорилтыг “зам, тээврийн ослын болон авто зогсоол дээрх хөдөлгөөний улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, даатгуулагч болон хохирогчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор автотээврийн хэрэгслийн өмчлөгчийг заавал даатгалд хамруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж өөрчлөн найруулав. Ийнхүү төсөлд тусгаснаар жолоочийн даатгалд зөвхөн тээврийн хэрэгслийн өмчлөгч даатгуулах бөгөөд жолооч замын хөдөлгөөнд оролцож байхдаа бусдад учруулсан хохиролд нөхөн төлбөр олгодог өнөөгийн зохицуулалтыг өөрчилж авто зогсоолд автотээврийн хэрэгсэл хөдөлгөөнд орсон үед бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг нээж өгөв.

Даатгалын хураамжийг тогтоохдоо “зардлыг хамгийн бага байлгах” зарчмыг баримталж, даатгалын хураамж, үнэлгээний хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, инфляц болон эрсдэлийн түвшинтэй тус тус уялдуулан тухай бүр тогтоох зохицуулалтыг бий болгоно. Даатгалын хураамжийг эрсдэл дээр тулгуурлан даатгалын мэргэшсэн ажилтнуудын тооцоолол болон саналыг харгалзан тогтоох нь хураамж илүү нарийвчлалтай, үндэслэлтэй болгох боломжийг бүрдүүлж, мөн даатгалын салбарын мэргэжилтнүүдийн чадвар, хариуцлагыг дээшлүүлэх болно.

Цахимаар болон дэвшилтэд технологийг ашиглан даатгалын гэрээ байгуулах, нөхөн төлбөрийг шийдвэрлэх, даатгалын тохиолдлыг баталгаажуулах эрх зүйн орчин болон мэдээллийн сангийн зохицуулалтыг сайжруулснаар хөгжингүй улс орнуудад ашиглагдаж буй орчин үеийн ухаалаг даатгалын гэрээ, хохирол үнэлэх телематик төхөөрөмж, нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн систем зэрэг технологиуд нэвтэрснээр даатгалын компаниудын үйл ажиллагааны зардал буурах, даатгалын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх боломжийг бүрдүүлнэ. Улмаар энэ нь нийгмийн хариуцлагын кредит онооны систем хөгжих үндэс бий болж, нийгмийн оролцогч тал бүрд хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, түүний зохицуулалтыг сайжруулах түүчээ болох юм.

Даатгалын нөхөн төлбөр олгох харилцааг зохицуулсан журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтийг хангуулж ажилласнаар даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэлтийн хугацааны удаашрал болон нөхөн төлбөр олгохоос татгалздаг байдлыг тус тус бууруулах боломжтой болно.

Даатгагч нь даатгалын хохирол үнэлэгчийг заавал томилох үүрэгтэй байсныг өөрчилж, даатгагчийн томилсон хохирол үнэлэгч ажилтан нь даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, даатгуулагч тухайн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд даатгалын хөндлөнгийн хохирол үнэлэгчээр үнэлүүлэх эрхтэй байхаар өөрчлөн найруулав. Мөн даатгалын тохиолдлыг шалгаж, хохирлыг үнэлэх, эд хөрөнгийн хохирлын нөхөн төлбөр олгох хугацааг ажлын 10 өдөр гэж тусгаж, нөхөн төлбөр шийдвэрлэх хугацааг 2-3 дахин багасгасан зохицуулалтыг тусгав.

Хуульд нөхөн төлбөр олгохгүй байхаар заасан даатгалын тохиолдлуудаас зөвхөн амь нас, эрүүл мэндийн хохиролд даатгагч нарын хамтран байгуулах хохирогчийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгдсэн зохион байгуулалттай Холбоо даатгалын нөхөн төлбөр олгохоор тусгалаа. Энэхүү үйл ажиллагааг даатгагч нар өөрсдөө хариуцан явуулснаар хохирогч даатгалтай болон даатгалгүй аль ч тохиолдолд хохирогчийн амь нас, эрүүл мэндийн хохиролд даатгалын нөхөн төлбөр авах боломжийг бүрдүүлж, улмаар даатгалын салбарын нэр хүндийг өсгөх, зохион байгуулалтын бүтцийнхээ хүрээнд шуурхай албыг байгуулж, шийдвэрлэх давуу талыг бий болгов.

Түүнчлэн Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 48 дугаар тэмдэглэлээр хуулиар тусгайлан олгосон зохицуулалтыг 2 дахин бууруулах чиглэл баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасан. Үүнтэй холбоотойгоор одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Жолоочийн даатгалын тухай хуульд Захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгогдсон нийт 7 акт буюу журам гаргах заалт байгааг дахин хянан үзээд, 4 журмыг хасаж, 2 журам шинээр нэмж, нийт 5 журам, мөн 2 тогтоол батлан гаргахаар өөрчлөн найруулан, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган боловсрууллаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2022 оны 5, 6, 11 дүгээр сар, 2023 оны 12 сард, нийт 4 удаа салбарын мэргэжлийн холбоод болон даатгагч нарыг оролцуулан зохион байгуулж, хуулийн төслийг хуулийн төслийн үзэл баримтлал болон бусад холбогдох судалгааны хамт Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан. Дээрх хэлэлцүүлгүүд болон цахим

хуудсанд байршуулах хүрээнд уг хуулийн төсөлд цахимаар болон албан бичгээр нийт 139 саналыг ирүүлснийг ажлын хэсэг судлан үзэж, 23 саналыг хуулийн төсөлд тусган боловсруулж, 116 саналыг хуулийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн. Хуулийн төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн саналын үндэслэл бүхий тайлбарыг товъёгийн хамт боловсруулж, мөн цахим хуудсанд байршуулсан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулж хэрэгжүүлснээр даатгалын зах зээлийн чанар, үйлчилгээ сайжрах, даатгалын хураамж, үнэлгээ нь олон улсын жишигт нийцэж бодит үнэлэмжээр тогтох, төрийн оролцоо буурах, даатгалын хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа улам боловсронгуй болох, зам тээврийн ослын аливаа тохиолдолд хохирогчийн эрх ашиг хамгаалагдах ач холбогдолтой юм.

---oOo---